



**ХАЛДВАРТ ӨВЧИН
СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2023 оны 04 сарын 24 өдөр

Дугаар А/485

Улаанбаатар хот

┌ Журам батлах тухай ┐

Эрүүл мэндийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.4, 16.16 дахь заалт, Эмнэлгийн тусламжийн тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1.2, 8 дугаар зүйл 8.1 дэх заалт, Эмнэлгийн мэргэшсэн тусламж үйлчилгээ үзүүлэх 2018 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн А/485 дугаар тушаал, төрөлжсөн мэргэжлийн эмнэлгийн бүтэц үйл ажиллагааны стандарт MNS 6330:2017, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн дүрмийн 5 дугаар зүйлийн 5.3 дугаар заалт, Хөдөлмөрийн дотоод журмын 3.2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус төвийн “Мэс заслын тасгийн ажиллах журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, “Мэс заслын зөвлөгөөн хийх журам”-ыг хоёрдугаар хавсралтаар, “Мэс заслын тасгийн тусламж үйлчилгээний жагсаалт”-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү журмыг эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлж буй нийт эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтэнд танилцуулахыг Эмнэлгийн тусламж үйлчилгээ эрхэлсэн дэд захирлын үүргийг түр хавсран гүйцэтгэгч (Ж.Ариунбилэг)-т, хэрэгжүүлэн ажиллахыг нийт алба тасгийн дарга, эрхлэгч нарт тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Чанарын албаны даргын үүргийг түр хавсран гүйцэтгэгч (Б.Энхжаргал)-д үүрэг болгосугай

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Ц.БИЛЭГТСАЙХАН

ХӨСҮТ		Боловсруулсан огноо		2023.03.15
		Баталсан огноо		
		Хуудасны тоо		10
Тушаалын дугаар	А/	БАТАЛСАН	Ерөнхий захирал Ц.Билэгтсайхан	
Мөрдөж эхлэх огноо	2023.03.15			

МЭС ЗАСЛЫН ТАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

Баримт бичгийн төлөв	Боловсруулсан	Хянасан		Хянасан огноо
		Чанарын албаны дарга	Эмнэлгийн тусламж үйлчилгээ эрхэлсэн дэд захирал	
	Чанарын албаны менежер	Б.Энхжаргал	Ж.Ариунбилэг	
	О.Эрдэнэболор 2023.03.15			


ӨӨРЧЛӨЛТИЙН БҮРТГЭЛ

"Бүртгэл хяналтын журам"-ыг жилд 1-ээс доошгүй удаа хянана. Журамд тусгах шаардлагатай өөрчлөлтийг хэлэлцэж удирдах албан тушаалтнаар баталгаажуулна.

Журамд оруулсан өөрчлөлтийг доорх "Өөрчлөлтийн бүртгэл"-д тэмдэглэнэ.

Өөрчлөлт оруулсан бүлэг/зүйл	Өөрчлөлтийн товч утга	Сүүлд шинэчлэгдсэн огноо	Боловсруулж, шинэчилсэн албан тушаалтан, овог, нэр	Баталсан албан тушаалтан, овог, нэр

ХӨСҮТ-ийн Ерөнхий захирлын
2023 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн
№ 73 тоот тушаалын нэгдүгээр хавсралт



МЭС ЗАСЛЫН ТАСГИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Тус төвөөс үйлчлүүлэгчид үзүүлж байгаа мэс заслын тусламж үйлчилгээг чанар, хүртээмжтэй үзүүлэх, хяналт тавих, тусламж үйлчилгээг тасралтгүй сайжруулах үйл ажиллагааг тодорхой болгох нь энэхүү журмын зорилго оршино.

1.2. Уг журам нь ISO 9001:2015 чанарын менежментийн тогтолцооны стандартын шаардлагад нийцсэн болно.

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

Тус төвийн мэс заслын тасгийн үйл ажиллагаанд хамаарна.

ГУРАВ. ҮЙЛ ЯВЦ

3.1 Мэс заслын тасагт яаралтай тусламжийн тасаг, амбулатори, бусад эмчилгээний тасгаас мэс заслын тасагт үйлчлүүлэгч ирэхэд ээлжийн сувилагч, туслах сувилагч хүлээн авч хуваарьт өрөөнд оруулна.

3.2 Сувилагч үйлчлүүлэгчийн амин үзүүлэлтийг үзэж сувилгааны маягт 2-ийг бөглөнө. Ажлын цагаар тасгийн эрхлэгч эмчид, ажлын бус цагаар тухайн тасгийн жижүүр эмчид мэдэгдэнэ.

3.3 Эмч нь эмнэлзүйн заавар, удирдамжийн дагуу үзлэг хийн цахим өвчний түүхийг хөтөлнө. Төлөвлөгөөт мэс заслыг эмч нарын зөвлөгөөнөөр, яаралтай мэс заслыг тухайн үеийн жижүүр эмч, мэс заслын зөвлөх эмч, мэдээгүйжүүлгийн эмч нарын хамтарсан зөвлөгөөнөөр шийдвэрлэнэ.

3.4 Мэс засалд орох үйлчлүүлэгчийг тухайн ээлжийн сувилагч, туслах сувилагч нь мэс заслын өрөөрүү зөөвөрлөнө.

3.5 Мэс заслын баг үйлчлүүлэгчид мэс заслыг хийж, мэс заслын дараах сэрээх өрөөнд 2 цагаас илүүгүй ажиглана, Үүний дараа үйлчлүүлэгчийн биеийн байдлаас хамаарч мэс заслын эсвэл эрчимт эмчилгээний тасагт шилжих асуудлыг мэс заслын болон мэдээгүйжүүлэгч эмч нар хамтран шийдвэрлэнэ.

3.6 Эмч нарын зөвлөгөөний Төлөвлөгөөт мэс засалд орох бол шинжилгээ бүрдүүлэн шинжилгээний дүгнэлтийг үндэслэн мэс заслын эмч, бусад төрөлжсөн мэргэжлийн

эмч , зөвлөх эмч, мэдээгүйжүүлэгч эмч нарын хамтарсан зөвлөгөөнөөр онош, мэс засал хийгдэх эсэх, мэс засалд орох хугацааг төлөвлөнө.

3.7 Мэс засал хийлгэсэн үйлчлүүлэгчийг эмнэлгээс гарах үед зөвлөгөө өгөн харьяа дүүрэг болон аймгийн мэс заслын эмчийн хяналтад эмчилгээг үргэлжлүүлэхээр гаргана. Бусад тасгаас ирсэн тохиолдолд тасагт нь зөвлөгөө өгөн шилжүүлнэ

ДӨРӨВ.ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ҮҮРЭГ

4.1 Үйлчлүүлэгч өөрийнхөө болон гэр бүлийнхээ эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, урьдчилан сэргийлэх

4.2 Эрүүл мэндийн байгууллагын ажилтантай хүндэтгэлтэй харилцаж, соёлтой үйлчлүүлэх

4.3 Байгууллагын дотоод дүрэм, журмыг дагаж мөрдөх

4.4 Эмчилгээ, үйлчилгээний заавар, дэглэмийг чанд сахих

4.5 Бусдын эрхийг хүндэтгэх

4.6 Эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлж байхад зураг авах болон дуу, дүрс бичлэг хийхгүй байх

4.7 Өөрийн болон асран хамгаалж буй үйлчлүүлэгчийн биеийн байдал, эрүүл мэндийн талаарх мэдээллийг эмнэлгийн мэргэжилтэнд үнэн зөв, бүрэн мэдээлэх

ТАВ. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ЭРХ

5.1 Үйлчлүүлэгч нь эрүүл мэндийн чанартай, тэгш, хүртээмжтэй тусламж, үйлчилгээг авах эрхтэй

5.2 Биеийн эрүүл мэндийн байдал болон эмчилгээ, үйлчилгээний үр дүн, өвчний явц, цаашид хийх эмчилгээ, гарч болох үр дагаврын талаар мэдээлэл авч, эмнэлгийн мэргэжилтэнтэй харилцан ярилцах, тайлбар авах эрхтэй.


5.3 Өөрийн эрүүл мэндийн талаарх нууцаа хамгаалуулах эрхтэй.

5.4 Эмчээ сонгон эмчлүүлэх, тусламж үйлчилгээний явцад эмчлэгч эмчээ солих санал тавих эрхтэй.

ЗУРГАА.ЭРГЭЛТИЙН ЦАГИЙН ХУВААРЬ

6.1 Эргэлтийг өдөр бүр 14:00-18:00 цагийн хооронд. Жич: Шинээр хэвтсэн эмчлүүлэгчийн эргэлтийг ирсэн тухайн үед нь оруулах

ХӨСҮТ-ийн Ерөнхий захирлын
2023 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн
№73 тоот тушаалын хоёрдугаар хавсралт



МЭС ЗАСЛЫН ЗӨВЛӨГӨӨН ХИЙХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Төлөвлөгөөт мэс засалд орох үйлчлүүлэгчдийг хэвтүүлэх, уушгины болон уушгины бус сүрьеэгийн онош эргэлзээтэй үйлчлүүлэгчийн оношилгоо, шинжилгээ, эмчилгээний асуудлыг шийдвэрлэх, мэс засал хийх боломжгүй эмчлүүлэгчийн цаашид хийх эмчилгээний зарчим, мэс заслын ачааллыг зохицуулахын тулд мэс заслын зөвлөгөөн хийнэ.

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

Тус төвийн мэс заслын тасгийн үйл ажиллагаанд хамаарна.

ГУРАВ. ҮЙЛ ЯВЦ

1. Мэс заслын зөвлөгөөнийг долоо хоног бүрийн баасан гаригт 10⁰⁰ - 12⁰⁰ цагийн хооронд амбулаторийн эмчийн шинжилгээ бүрдүүлсэн дараалалтайгаар зохион байгуулна.
2. Мэс заслын зөвлөгөөнийг мэс заслын тасгийн эрхлэгч удирдан зохион байгуулна.
3. Мэс заслын зөвлөгөөний бүрэлдэхүүнд мэс засал, мэдээгүйжүүлгийн эмч шаардлагатай тохиолдол дүрс оношилгоо болон бусад мэргэжлийн эмч нар хамтран мэс заслын зөвлөгөөнд орсон үйлчлүүлэгчдийн тусламж үйлчилгээний асуудлыг шийдвэрлэнэ.
4. Мэс заслын тусламж үйлчилгээ авах үйлчлүүлэгчдийг өвчин эмгэгийн хүндийн зэрэг, эрэмбэлэлт зэрэгт үндэслэн эмнэлэгт хэвтүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.
5. Тус төвийн мэс заслын тасагт тусламж үйлчилгээ авах шаардлагатай үйлчлүүлэгчдийг сүрьеэгийн амбулаторийн эмчийн бичигтэй, лабораторийн болон дүрс оношилгооны шинжилгээг бүрдүүлсэн байна.
6. Хэрэв үйлчлүүлэгчийн онош эргэлзээтэй өөр бусад шинжилгээг бүрдүүлэх шаардлагатай бол уг шинжилгээг хийлгэсний дараа дахин зөвлөгөөнөөр оруулж асуудлыг шийдвэрлэнэ.
7. Мэс засалд орох үйлчлүүлэгчдийн тоо төлөвлөсөн ачааллаас их бол хүлээгдэлд оруулж бүртгэнэ.

32		Арьсны гаднаас давсаганд гуурс тавих	57.17	
33	Яс, үеэнд хийгдэх мэс заслууд A18.0	Нугалам хоорондын жийрэгвчийг авах /дискэктомия/	80.51	
34		Өвдөгний үеийг хөдөлгөөнгүй болгох ажилбарууд	81.22	
35		Өвдөгний үений эмгэг эдийг авах, тайрах	80.8	
36		Хүзүүний C2 буюу түүнээс доошхи нугаламд хийгдэх мэс засал	81.03	
37		Багана нуруунд хийгдэх бусад мэс ажилбарууд	81.6	
38		Шагайн үеэнд хийгдэх мэс ажилбарууд	81.11	
39		Түнхний үеийг хөдөлгөөнгүй болгох	81.21	
40		Түнхний үеийг сэргээн засах ажилбар	81.40	
41		Бүсэлхий, ууцны хэсэгт хийгдэх мэс ажилбарууд	81.07	
42		Сарвуу, хуруу, бугуйн үеийг нөхөн сэргээх, сэргээн засах	81.7	
43		Мөрний үеийг сэргээн засах бусад ажилбарууд	81.83	
44		Тохойн үеийг сэргээн засах бусад ажилбарууд	81.85	
45		Бусад оношлогоо, эмчилгээний ажилбарууд A18.2	Хүзүүний гүндэх тунгалагийн зангилааг тайрах	40.2
46			Хөхөн доторх тунгалагийн зангилааг тайрах	40.22
47	Суганы хонхорын тунгалагийн зангилааг тайрах		40.23	
48	Цавины тунгалагийн зангилааг тайрах		40.24	
49	Бусад тунгалагийн зангилааг тайрах		40.29	
50	Хүзүүний нэг талыг төгс авах		40.41	
51	Хүзүүний хоёр талыг төгс авах		40.42	
52	Эр бэлэг эрхтэн ба эх барихын ажилбарууд	Нэг талын төмсөг авах мэс ажилбар	62.3	
53		Хоёр талын өндгөвч авах мэс ажилбар	65.51	
54		Нэг талын өндгөвч авах мэс ажилбар	65.3	
55		Умайг хэвлийгээр авах төгс хагалгаа	68.9	
56		Умайг үрийн хоолой ба өндгөвчийг авахтай хавсаргах	65.31	
57		Умайн доод хэсгээр хийх кесвар хагалгаа	74.1	

8. Мэс заслын зөвлөгөөнөөс гарсан шийдвэрийг тасгийн ахлах сувилагч бичиж тэмдэглэнэ.

9. Ар гэр, асран хамгаалагчид зөвлөгөөнд хамт оролцох эрхтэй

10. Мэс заслын зөвлөгөөнөөс гарсан мэс засалд орох хувиарыг Эмнэлгийн тусламж үйлчилгээ эрхэлсэн дэд захирлаар батлуулна.

ДӨРӨВ. ТӨЛӨВЛӨГӨӨТ МЭС ЗАСАЛД ОРОХОД ШААРДЛАГАТАЙ ЗҮЙЛС

4.1 Хөдөө, орон нутаг болон Улаанбаатар хотын үйлчлүүлэгчид харъяа сүрьеэ диспансерийн эмчээс ТВ-09 маягт авч ирэх

4.2 Мэс заслын тасгийн амбулаторийн эмчид үзүүлж зөвлөгөөнд орох хэвтэх бичиг авна.

4.3 Мэс заслын зөвлөгөөний эмч нарын шийдвэр, хийх мэс засал тодорхой болсон байна.


4.4 Зөвлөгөөнд орох эмчлүүлэгч доорх шинжилгээг заавал бүрдүүлсэн байх.

Үүнд: / 14 хоногийн дотроо хүчинтэй/

- Биохими /элэг, бөөрний үйл ажиллагаа үзэх/
- Цусны ерөнхий шинжилгээ
- Шээсний ерөнхий шинжилгээ
- Коауглограмм
- Вирусын маркери
- ДОХ,серологийн шинжилгээ
- Зүрхний цахилгаан бичлэг /ЭКГ/
- Цусны бүлэг
- Цэр /өсгөвөр, түрхэц/
- Уушгины дуран /БАЛ /- уушгины мэс засал
- СТ, MRI /тухайн оношийн дагуух/
- Амьсгалын багтаамж үзүүлсэн байх /Уушгины мэс засал/
- Зүрхний ЭХО /бүтэн уушги тайрах, шаардлагатай бол /



МЭС ЗАСЛЫН ҮЙЛДЛИЙН ОЛОН УЛСЫН АНГИЛАЛ, ОНОШИЙН КОД



д/д	Хийгдэх мэс заслын төрөл, ангилал	ҮОУА код	
1	АЭТ-нд хийгдэх мэс засал А15.А16	Дэлбэнг хэсэгчлэн тайрах - атипичная резекция	32.3
2		Дэлбэнг тайрах - лобэктомия	32.4
3		Уушиг бүрэн тайрах - пульмон эктомия	32.5
4		Цээжний хөндийг нээх - открытая торокотомия	34.02
5		Торокомиопластика	33.34
6		Цээжний хөндийд гуурс тавих	34.0
7		Эмпиемийг авах	34.06
8		Цээжний гялтанг авах - декортикаци плеврэктомия	34.51
9	ЗС-ны эрхтэн тогтолцоонд хийгдэх мэс засал А18.3	Үнхэлцэг хальсыг зүсч нээх /перикардид цонх үүсгэх/	37.12
10		Үнхэлцэг хальснаас эдийн шинжилгээ авах	37.24
11		Үнхэлцэг хальс авах	37.31
12		Аневризмыг хавчих	39.51
13	Хэвлийн хөндийн эрхтэн тогтолцоонд хийгдэх мэс заслууд А18.3	Хэвлийн гялтангаас эдийн шинжилгээ авах /чацархай, сэмж, гялтан/	54.23
14		Хэвлийн гялтан угаах	54.98
15		Хэвлийн гялтангийн эдийг тайрах /сэмж бүтэн тайрч авах/	54.4
16		Ходоодны бусад эд, эмгэг эдэд хэсэгчлэн тайралт хийх	43.42
17		Нарийн гэдэс тайрах мэс засал	45.6
18		Нарийн гэдэсний бусад хэсэгчлэн тайралт	45.71
19		Мухар гэдсийг тайрч авах	45.72
20		Нарийн гэдсийг нарийн гэдэстэй залгах	45.91
21		Нарийн ба бүдүүн гэдсийг залгах бусад залгааснууд	45.93
22		Бүдүүн гэдэс, бүдүүн гэдэсний залгаас	45.94
23		Нарийн гэдэс гадагш гаргах	46.01
24		Бүдүүн гэдэс гадагш гаргах	46.03
25		Хошногоны цоргыг зүсэх, тайрах	49.1
26		Хошногоноос эдийн шинжилгээ авах	49.23
27		Цөсний хүүдийг авах	51.22
28		Цөсний чулуу авах	51.04
29		Эвэрхийг засах /нөхөх, оёх, нээх/	53
30		Хэвлийг нээж шалгах, хэвлийн хөндийн хагалгааны үед хоёрдогчоор шалгах	54.11
31		Бөөрийг бүхлээр нь авах	55.5